



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 01 сарын 28 өдөр

Дугаар 27

Улаанбаатар хот

Зөвлөлийн бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (С.Ламбаа)-д үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэнд, спортын сайдын 2015 оны 26 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ



Ц.ОЮУНБААТАР

080090

Эрүүл мэнд, спортын сайдын
2016 оны 01 сарын 28 өдрийн
27 дугаар тушаалын хавсралт



**Эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэх
зөвлөлийн бүрэлдэхүүн**

- Зөвлөлийн дарга: Эрүүл мэнд, спортын яамны Төрийн нарийн бичгийн дарга
- Орлогч дарга: Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын дарга
- Нарийн бичгийн дарга: Эрүүл мэнд, спортын яамны Стратегийн бодлого төлөвлөлтийн газрын Үндсэн ба төрөлжсөн мэргэжлийн эрүүл мэндийн байгууллагын магадлан итгэмжлэлийн хэрэгжилтийн зохицуулалт хариуцсан мэргэжилтэн
- Гишүүд:
- Эрүүл мэнд, спортын яамны Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Эмнэлгийн тусламжийн хэлтсийн дарга
 - Нийгмийн даатгалын ерөнхий газрын Эрүүл мэндийн даатгалын газрын дарга (зөвшилцсөнөөр)
 - Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын газрын Эрүүл мэндийн хяналтын хэлтсийн дарга (зөвшилцсөнөөр)
 - Монголын хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбооны төлөөлөл (зөвшилцсөнөөр)
 - Эрүүл мэндийн чанарын менежерүүдийн холбооны төлөөлөл (зөвшилцсөнөөр)
 - Эрүүл мэндийн удирдах ажилтны нийгэмлэг (зөвшилцсөнөөр)